



“ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН”

Алтан Нар (алт-полиметаллын) төслийн NI 43-101 стандартын дагуу хийгдсэн техникийн тайланг нийтлэв

Канад улс, Нова Скошиа муж, Халифакс хот – 2018.06.25

Эрдэнэ Ресурс Девелопмент Корп. (TSX:ERD | MSE:ERDN) (цаашид “Эрдэнэ” эсвэл “Компани” гэх) нь өөрийн 100% эзэмшил бүхий Алтан Нар (“Алтан Нар”), алт-полиметаллын төслийн хөндлөнгийн техникийн тайланг Канад улсын “Эрдсийн төслийн мэдээллийг олон нийтэд тайлагнах стандартын” (“NI 43-101”) дагуу хөрөнгө оруулагчдад нийтэлснээ зарлалаа. Тайланг RPMGlobal (“RPM”) компани 2018 оны 6 сарын 21-ны байдлаар бэлтгэсэн бөгөөд Канад улсын хувьцаат компаниудын мэдээлэл түгээх цахим талбар болох SEDAR (www.sedar.com)-д “Altan Nar Gold Project, Bayankhongor Aimag, Southwest Mongolia, National Instrument 43-101 Mineral Resource Technical Report” нэртэйгээр нийтэллээ. RPM нь олон улсын болон бүс нутгийн хэмжээнд уул уурхайн бүтээгдэхүүн, аргачлалын чиглэлээр мэргэшсэн дэлхийн хамгийн том хөндлөнгийн техникийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм.

Энэхүү техникийн тайланд Компанийн 5-р сарын 10-нд олон нийтэд зарласан Алтан Нар төслийн шинэчилсэн нөөцийн тооцоололтой холбоотой техникийн мэдээллүүд агуулагдсан болно. ([линк-ээр танилцана уу.](#))

Алтан Нар алт-полиметаллын төслийн тухай

Алтан Нар төслийн талбай нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт, Компанийн Баян Хөндий алтны төслөөс баруун хойш 16 км зайд Хөндий алтны дүүрэгт байрладаг. (Баян Хөндий төслийн анхан шатны нөөцийн тооцооллыг 2018 оны 3 дугаар улиралд танилцуулахаар төлөвлөж байна.) Компанийн тооцоолсноор Алтан Нар төслийн бодит нөөц нь дунджаар 2.8 г/т алтны эквивалент (алтны дүйцэх нэгж “AuEq”) (2.0 г/т алт, 14.8 г/т мөнгө, 1.2% хар тугалга, цайр) агуулгатай 5.0 сая тн хүдэрт 452,900 унц, боломжит нөөц нь 3.4 сая тн хүдэрт 2.5 г/т AuEq (1.7 г/т алт, 7.9 г/т мөнгө, 1.4% хар тугалга, цайр) агуулгатай 277,100 унц агуулагдаж байна. AuEq-г тооцохдоо нэг унц алтыг 1,310 ам.доллар, нэг унц мөнгийг 18 ам.доллар, хар тугалгыг нэг тонн нь 2,400 ам.доллар болон нэг тонн цайрыг 3,100 ам.доллар гэж авч үзсэн. Мөн металл авалтыг алтны хувьд 88%, мөнгө 81%, хар тугалга 81%, цайр 60% байхаар тооцоолсон.

Компанийн 2015 оны 3 дугаар сард танилцуулсан Алтан Нар анхан шатны нөөцийн тайлангаар харьцуулахад бодит AuEq нөөц нь 208%, боломжит AuEq нөөц нь 172%-аар өссөн байна. Алтан Нар төслийн талбайд хийгдсэн 122 өрөмдлөгийн цооногуудын дундаж гүн 157 метр байсан бөгөөд нийт нөөцийн 90% нь газрын гадаргаас 150 метрээс илүүгүй гүнд, бүсүүд нь бүгд суналын дагуу, гүндээ нээлттэй байна. 5.6 км урттай Алтан Нарын хүдэржилтийн корридор өрөмдлөгийн ажил хийгдээгүй болон анхан шатны өрөмдлөг хийгдсэн хэтийн төлөв бүхий хэд хэдэн хайгуулын талбай байгаа нь алт-полиметаллын нэмэлт нөөцийг агуулж байх боломжтой.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корп. нь Монгол улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол улсын баруун урд бүсэд өндөр агуулга бүхий газрын гадаргад ойр Баян Хөндий алтны төсөл, Баян Хөндий төслийн талбайгаас 16 км зайд орших өндөр агуулга бүхий газрын гадаргатай ойр алт-полиметаллын Алтан Нар төсөл, Баян Хөндий төслийн талбайтай залгаа орших зэс-алтны порфирын хайгуулын Улаан талбай, Баян Хөндий төслийн талбайгаас хойд зүгт 3.5 км-т орших өндөр агуулга бүхий алт-мөнгөний Алтан Сум төсөл, хөгжүүлэлтийн эхний шатанд явж буй зэс-мөнгөний порфирын Хөвийн Хар төсөл, өндөр агуулга бүхий зэс-алтны Номин Тал нээлт, томоохон молибден-зэсийн порфирын Зуун Мод орд зэрэг төслүүдийн хүрээнд 4 хайгуулын, 1 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Үүнээс гадна, Монгол улсын баруун урд зүгт, Транс Алтайн бүсэд Канад улсын Тек Ресурс компанитай хамтарсан бүс нутгийн зэс-алтны хайгуулын үйл ажиллагааг эрхэлж байна. Компани нь Баян Хөндий, Алтан Нар төслүүдийн тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд 2%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөр ("NSR")-ийг Сэндстормд төлөх үүрэгтэй бөгөөд төлбөрийг 1% хүртэл бууруулах боломжтой. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com-оос авч, танилцах боломжтой. Эрдэнэ нь 161,775,791 ширхэг Энгийн хувьцаа, хорогдуулах боломжит 185,951,320 Энгийн хувьцаатай болно.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш болно. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН
ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН
МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер С. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал
Кэн В.МакДоналд, Дэд ерөнхийлөгч болон Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419
Емэйл: info@erdene.com
Вебсайт: www.erdene.com
Твиттер: <https://twitter.com/ErdeneRes>